

**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Ж.ҮҮРИЙНТУЯАГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

№	Зорилгыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (Биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4			
Зорилго 1. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ							
1.	Арга хэмжээ 1.1 Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг ханган ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0%	60%	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, “Бүтээн байгуулалтын жил”-ийн жилийн төлөвлөгөө, НЗДТГ, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн албан бичиг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн шуурхай үүрэг даалгавар, МУ-ын Ерөнхий сайдын албан даалгавар, Хуульд заасан зарим чиг үүргийг Төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ, ЗГ-ын Авлигатай тэмцэх Шил ажиллагаа зэрэг төлөвлөгөө, үүрэг даалгавруудын биелэлт, хэрэгжилтийг ханган ажиллалаа.	06-12	100%
2.	Дэд арга хэмжээ 1.1.1: Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	Үндсэн арга хамжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	25%	НӨХГ-ын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний “Зорилго 2. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллана.” зорилгын хүрээнд	06-12	100%

					<ul style="list-style-type: none"> <p>НИТХ-ын тогтоолоор батлагдсан хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтын дагуу хувьчлалыг зохион байгуулах ажлын хүрээнд барилга байгууламж болон орон сууцны нээлттэй дуудлагын худалдаа зарлагдсан тухай зар мэдээг цахим сувгуудаар /байгууллагын цахим хуудас</p> <p>https://www.umch.ub.gov.mn/a/623</p> <p>https://www.umch.ub.gov.mn/a/669</p> <p>https://www.umch.ub.gov.mn/a/708 , олон нийтийн сүлжээний фэйсбүүк пэйж хуудас</p> <p>https://www.facebook.com/share/p/17m29Qq33n/</p> <p>https://www.facebook.com/share/p/1BWGu94A8h/</p> <p>https://www.facebook.com/share/p/1CTkDmWTwu/</p> <p>https://www.facebook.com/share/p/1BuoHgm4LS/ , Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн</p> <p>https://www.ulaanbaatar.mn/news/21662</p> <p>https://www.ulaanbaatar.mn/news/21663</p> <p>https://ulaanbaatar.mn/news/21441</p> <p>цахим хуудас,</p> <p>https://www.facebook.com/share/p/1AW4AUkgS7/</p> <p>https://www.facebook.com/share/r/1E9kxk23S7/</p> <p>https://www.facebook.com/share/p/1ADJz zaVP2/ Улаанбаатар мэдээ фэйсбүүк пэйж хуудсуудаар / болон Нийслэлийн</p> 	
--	--	--	--	--	---	--

					<p>өмч хувьчлах журмын хүрээнд 3-аас доошгүй сонингийн газар / Үндэсний өдөр тутмын сонин буюу Өнөөдөр, Зууны мэдээ, Монголын мэдээ болон Өдрийн сонин / -аар дамжуулан олон нийтэд мэдээллэх ажлыг 07 дугаар сарын 21-ээс 10 дугаар сарын 17-ны хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн.</p> <ul style="list-style-type: none"> • Нийслэлийн Засаг даргын нийслэлийн өмчит хуулийн этгээдийн данснаас хассан тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хүрээнд нээлттэй дуудлагын худалдаа зарлагдсан тухай зар мэдээг цахим сувгуудаар /байгууллагын цахим хуудас https://www.umch.ub.gov.mn/a/573 , олон нийтийн сүлжээний фэйсбүүк пэйж хуудас https://www.facebook.com/share/p/16jfv8oPUR/ , Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн цахим хуудас https://www.ulaanbaatar.mn/news/21373 https://www.facebook.com/share/p/17cxvVL1P1/ Улаанбаатар мэдээ фэйсбүүк пэйж хуудсуудаар / болон Нийслэлийн өмч хувьчлах журмын хүрээнд 3-аас доошгүй сонингийн газар / Үндэсний өдөр тутмын сонин буюу Өнөөдөр, Зууны мэдээ, Монголын мэдээ болон Өдрийн сонин / -аар дамжуулан олон нийтэд мэдээллэх ажлыг 06 дугаар 	
--	--	--	--	--	---	--

					<p>сарын 26-аас 07 дугаар сарын 28-ны хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн.</p> <p>“Зорилго 6. Мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл технологийг сайжруулна.” зорилгын хүрээнд</p> <ul style="list-style-type: none"> - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2-р зүйлд нээлттэй байхаар заасан мэдээллүүдийг байгууллагын албан ёсны цахим хуудас https://www.umch.ub.gov.mn/, шил ажиллагаа буюу https://shilen.gov.mn/home болон https://shilendans.gov.mn/organization/11573?ry=2025&group=117 -д дараах байдлаар бүрэн гүйцэт, ил тод байршуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. • НӨХГ-ын алсын хараа, зорилго, чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, тэргүүлэх чиглэл, бүтэц, зохион байгуулалтын талаарх мэдээлэл • Үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа, авлигын эсрэг үйл ажиллагааны ил тод байдалд холбогдох мэдээлэл, баримт бичгүүд • Байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл • 2024-2025 оны НЗД-ын захирамж, НИТХ-ын тогтоол, Газрын даргын тушаал, Газрын дүрэм, журмууд болон хууль зүйн актууд 	
--	--	--	--	--	---	--

					<ul style="list-style-type: none"> • Түүнчлэн <i>вэб сайтыг хөгжүүлэгч Sodonsolution ХХК-аас зааварчилгаа, зөвлөгөө авч сайтын засвар, хөгжүүлэлт, шаардлагатай байгаа цэс, график, текст, холбоосуудыг оруулж вэб сайт болон фэйсбүүк пэйжийн баяжилт, бүрдлийг хангаж ажиллалаа.</i> - Түүнчлэн байгууллагын цахим хуудас, олон нийтийн сүлжээний фэйсбүүк пэйж, https://www.facebook.com/umch.ub.gov.mn , юүтүб https://www.youtube.com/@%D0%9D%D3%A8%D0%A5%D0%93 , инстаграм https://www.instagram.com/umch_ub_official/ хуудсуудын хөтлөлт, ашиглалтыг хийж түүгээр дамжуулан байгууллагын дотоодын болон гадагшаа чиглэсэн үйл ажиллагааны мэдээ мэдээлэл, Нийслэл болон ННЗБ-уудын онцлох болон нийслэлийн бүтээн байгуулалтын жилтэй холбогдуулан мега төслүүдийн талаарх мэдээ мэдээллийг өдөр бүр нийтэлж, иргэд олон нийтэд хүргэх ажлыг хийж гүйцэтгэж байна. 		
3.	Дэд арга хэмжээ 1.1.2: 2025 оны нийслэлийн “Бүтээн байгуулалтын жил”-ийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	Үндсэн арга хамжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	25%	<p>Нийслэлийн Засаг даргын 2025.01.02-ны өдрийн “2025 оныг “Бүтээн байгуулалтын жил” болгон зарласан тухай А/01 дүгээр захирамжийг хяналтад хүлээн авсан.</p> <p>“Бүтээн байгуулалтын жил”-ийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас https://ulaanbaatar.mn/home болон https://www.facebook.com/UlaanbaatarMedeeMN Улаанбаатар мэдээ фэйсбүүк пэйж хуудсуудад</p>	06-12	100%

					<p>байршуулсан мега төслүүдийн танилцуулга, гүйцэтгэл, хэрэгжилтийн талаарх мэдээлэл, төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбоотой зар, мэдээг тогтмол байгууллагын цахим хуудас https://www.umch.ub.gov.mn/as/news/3 , олон нийтийн сүлжээний суегуудаараа дамжуулан иргэд, олон нийтэд мэдээллэн ажиллаж байна.</p> <p>НЗДТГ-аас 2025.03.28-ны 02-02/1865 дугаартай албан бичгээр ирүүлсэн Нийслэл хотод хэрэгжүүлэх 24 мега төслийн танилцуулгын хүрээнд албан хаагчид болон олон нийтэд үнэн, зөв мэдээллийг үе шаттайгаар танилцуулах албан даалгаврын хүрээнд ХЗХэлтсээс танилцуулсан танилцуулгын талаарх мэдээллийг https://www.umch.ub.gov.mn/a/264 https://www.umch.ub.gov.mn/a/308 холбоосуудаар олон нийтэд мэдээллэсэн.</p>		
4.	<p>Дэд арга хэмжээ 1.1.3: Хяналт шалгалтын байгууллага, дээд байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах</p>	<p>Үндсэн арга хамжээний гүйцэтгэлд эзлэх хувь</p>	0%	10%	<p>Дээд байгууллагаас ирүүлсэн дараах зөвлөмж, чиглэлийг хэрэгжилтийг ханган хугацаанд нь тайлагнан ажилласан. Үүнд</p> <p>1. Монгол улсын ЗГ-аас 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж, авлигатай тэмцэх таван Ш буюу Шүгэл, Шүүр, Шувуу, Шилжүүлэн авах болон Шил ажиллагааг хэрэгжүүлж буй. “Шил ажиллагаа”-г Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд хэрэгжүүлж ажиллах албан даалгаврын хүрээнд Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын тухай хуульд нээлттэй байршуулахаар заасан мэдээ мэдээллийг холбогдох албан хаагчдаас авч бүрдлийг</p>	06-12	100%

				<p>ханган https://www.umch.ub.gov.mn/ байгууллагын цахим хуудас дээр болон https://shilen.gov.mn/home системд байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод байршуулж,</p> <ul style="list-style-type: none"> • 2 дугаар улирлын тайланг 96,67% https://shilen.gov.mn/index-detail?reportId=6806ff4c6829550567c6c085&active=67ff15e019d3da2046023819&approvedDate=2025-07-23T23:31:49.335 ; • 3-р улирлын тайланг 84% https://shilen.gov.mn/index-detail?reportId=68b67fc12b6b563ef16b6223&active=68b659372b6b563ef16b566f&approvedDate=2025-11-01T22:08:29.47 үнэлгээтэй дүгнүүлэв. • 4-р улирлын тайланг 12 сарын 30-ны байдлаар ирүүлэх бөгөөд өмнөх улирлын үнэлгээ буурсан шалтгааныг тодруулан, байгууллагын веб хуудас хөгжүүлэгч компанитай холбогдон цахим хуудас дээрх засвар үйлчилгээг хийлгэв. <p>2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Шуурхай үүрэг даалгаврын биелэлт, МУ-ын Ерөнхий сайдын албан даалгавар, Хуульд заасан зарим чиг үүргийг Төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээний хэрэгжилтийн биелэлт, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн биелэлтүүдийг хангаж, тайлан мэдээг хугацаанд нь Тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэнд хүргүүлж ажиллав.</p>	
Зорилго 2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ					

5.	<p>Арга хэмжээ 2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйгээ ухамсарлан, хариуцлагаа дээшлүүлж, ажлын цагаа үр бүтээлтэй ашиглаж, таслалт, хоцролтгүй байх</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь</p>	0%	50%	<p>Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, үр бүтээлтэй цаг ашиглалт зэрэг нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсээс сар бүр зохион байгуулагддаг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлэх, сайн туршлагыг дэлгэрүүлэх, төрийн алба хаагчийн ажлын байрны зөөлөн болон ахисан түвшний ур чадварыг хөгжүүлэх, цахим платформын хэрэглээг нэвтрүүлэх, ашиглахтай холбоотой сургалтуудад тогтмол хамрагдаж байна. 2. МУ-ын Ёс зүйн хорооноос 11 дүгээр сарын 03-ны өдөр “Хүндэлье, энэрье” ёс зүйн нөлөөллийн сарын аянг зохион байгуулж эхэлсэн бөгөөд энэхүү аяны хүрээнд байгууллагын цахим хуудсуудаар дамжуулан <ul style="list-style-type: none"> • https://www.facebook.com/share/v/18wCYMQiYj/?mibextid=wwXlfr • https://www.facebook.com/share/p/1Bw8atAT6B/?mibextid=wwXlfr • https://www.facebook.com/share/p/1AtsPzqVG5/?mibextid=wwXlfr • https://www.facebook.com/share/v/1786vXUCfc/?mibextid=wwXlfr • https://www.facebook.com/share/p/17Wf7wnDkM/?mibextid=wwXlfr <p>ажлын орчин, гэр бүл, найз нөхдөө хүндэтгэх, эелдэг харилцааг бий болгох, дэмжих, урамшуулах соёлыг</p>	06-12	100%
----	---	--	----	-----	---	-------	------

					<p>ажлын орчиндоо төлөвшүүлэх зэрэг нөлөөллийн үйл ажиллагааг ёс зүйтэй холбоотой мэдээлэл, постер бэлтгэх, МУ-ын ёс зүйн хорооны тус аянтай холбоотой нийтэлсэн мэдээ мэдээлэл болон сургалт, сурталчилгааг иргэд, олон нийт, албан хаагчдад мэдээллэх үйл ажиллагааг хийж гүйцэтгэлээ.</p>		
6.	<p>Арга хэмжээ 2.2 Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах, гүйцэтгэлийг тайлагнах, ажлын үр дүнгийн сайжруулалтыг дээшлүүлэх, хэлтсийн төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь</p>	0%	60%	<p>Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, шилжүүлсэн албан бичгийг зөрчилгүй, цаг тухай бүрд шийдвэрлэж, биелэлтийг ханган, түүнчлэн Захиргаа удирдлагын хэлтсийн хагас жил, жилийн эцсийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж, тайланг хугацаанд ирүүлэн ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • <i>НЗДТГ, Нийслэлийн Статистикийн газар, Улаанбаатар театр ОНӨТҮГ, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ, Үндэсний дата төв болон Налайх дүүргийн ЗДТГ-аас ирүүлсэн албан тоот, бичгүүдийн хүрээнд холбогдох судалгааг авах, албан хаагчдад танилцуулах, арга хэмжээнд идэвхтэй хамруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Тэрбум мод үндэсний хөдөлгөөн буюу "Бүх нийтээр мод тарих өдөр", Олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшигийн эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, "Ногоон санаачилга 2025" туршлага, судалгааны өдөрлөг, Хүн ам, орон сууцны улсын тооллого, Төрийн байгууллагын нэгдсэн цахим</i> 	06-12	100%

					<p>хуудас GOV.mn холбоотой бичиг зэрэг нийт 11 албан бичгийг шийдвэрлэсэн ба биелэлттэй холбоотой мэдээ мэдээллийг ЗУХ-ийн ахлах мэргэжилтэнд тайлагнан ажиллалаа.</p> <ul style="list-style-type: none"> • Мөн хэлтэс, нэгжийн жилийн эцсийн төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа. 		
7.	<p>Арга хэмжээ 2.3 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намар мод тарих ажилд оролцох</p>	<p>Оролцсон байдал, хэрэгжилтийн хувь</p>	0%	50%	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025 оны хавар, намрын "Бүх нийтийн мод тарих", тариалсан мод, бут, сөөгийг арчлан хамгаалах арга хэмжээг зохион байгуулж, ажлын гүйцэтгэлийг байгууллагын, хэлтэс нэгжийн, үүрэг даалгаврын биелэлтийн тайлан мэдээнд нэгтгэж ажиллалаа.</p> <ul style="list-style-type: none"> • 2025.05.03-ны өдөр Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнд шинээр 160 хайлаас мод, • 2025.10.14-ны өдөр 15 монос мод тарьж, өнгөрсөн онуудад тарьсан мод, бут, сөөгний усалгаа, арчилгааг хийсэн. <p>2025.05.03-ны өдрийн ажлын гүйцэтгэлийн мэдээг байгууллагын цахим хуудасны байгууллагын мэдээ, мэдээлэл хэсэгт https://www.umch.ub.gov.mn/a/411 нийгмийн сүлжээний фэйсбук платформ https://www.facebook.com/umch.ub.gov.mn -оор болон <i>ub. Egr</i> сүлжээнд олон нийтэд нээлттэй мэдээлсэн.</p> <p>2025.10.14-ны өдрийн ажлын гүйцэтгэлийн мэдээг видео хэлбэрээр бэлтгэн байгууллагын</p>	06-12	100%

					цахим хуудасны байгууллагын мэдээ, мэдээлэл хэсэгт https://www.umch.ub.gov.mn/a/1005 нийгмийн сүлжээний фэйсбук платформд https://www.facebook.com/reel/666752533154985 , болон юүтүб хуудсууд https://www.youtube.com/watch?v=97NQCetesPk дээр тус тус олон нийтэд нээлттэй мэдээллэв.		
8.	Арга хэмжээ 2.4 Хавар, намрын “Бүх нийтийн их цэвэрлэгээ”-нд оролцох	Оролцсон байдал, хэрэгжилтийн хувь	0%	50%	<p>2025 онд Нийслэлийн хэмжээнд “Бүх нийтийн их цэвэрлэгээ” 1 удаа зохион байгуулагдсан.</p> <ul style="list-style-type: none"> • <i>Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн “Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний тухай” А/354 дүгээр захирамжийн дагуу Арслантай гүүрнээс Дамдинсүрэнгийн гудамжны гүүр хүртэл Сэлбэ голын баруун талын зам дагуу түүвэр хог хаягдлыг цэвэрлэж, цэвэр цэмцгэр орчныг бүрдүүлэхэд оролцож, захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.</i> • <i>Тус үйл ажиллагааны хэрэгжилтийг байгууллагын цахим хуудас https://www.umch.ub.gov.mn/a/241 болон нийслэлийн UB.ERP системд, хэрэгжилтийн тайланг гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, мэдээнд нэгтгэж ажиллалаа.</i> 	02-12	100%
Зорилго 3. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАН АЖИЛЛАХ							
9.	Арга хэмжээ 3.1 Байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0%	80%	1. 2026 онд байгууллагын гадаад харилцааг өргөжүүлэх, хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор "Гадаад харилцаа, хамтын ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулахаар	06-12	20%

	<p>төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг тайлагнах</p>			<p>төлөвлөөд байна. Тус баримт бичигт дараах хамтын ажиллагааны зорилт, чиглэл, хэлбэрүүдийг тусгахаар судалж байгаа бөгөөд үүнд;</p> <ul style="list-style-type: none"> • <i>Байгууллагын богино, дунд, урт хугацааны стратегийн зорилтуудтай уялдуулах.</i> • <i>Олон улсын, бүс нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг бий болгож, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх санал боловсруулах.</i> • <i>Түншлэлтэй байсан байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хамтарсан арга хэмжээ зохион байгуулах.</i> • <i>Нийслэлийн өмчийн удирдлагын ил тод байдал, өмчийн бүртгэл, ашиглалт дижитал системийг сайжруулахад чиглэсэн олон улсын инновац, туршлага судлах, нэвтрүүлэх.</i> • <i>Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ ба менежментийн компаниудтай хамтын ажиллагааны гэрээ, контракт байгуулах.</i> • <i>Хамтын ажиллагааны хүрээнд туршлага солилцох айлчлал, зөвлөгөөн зохион байгуулах.</i> • <i>Гадаад хамтын ажиллагаатай холбоотой санхүүгийн солонгорсон эх үүсвэртэй болох.</i> • <i>Гадаад харилцааны мэргэжилтний гадаад хэл болон олон улсын харилцааны чадавхыг нэмэгдүүлэх.</i> 		
--	--	--	--	--	--	--

				<ol style="list-style-type: none">2. 2025 онд ННЗБ болон бусад төрийн байгууллагаас албан бичгээр ирүүлсэн хамтран ажиллах, санал өгөх, мэдээлэл ирүүлэх, тооллогод хамрагдах тухай албан бичгүүдэд цаг тухай бүрд албан бичгээр, мэйл хаягаар, тайлан мэдээгээр хариуг хүргүүлэн ажиллалаа.3. Үндэсний дата төв УТҮГ-тай 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Төрийн байгууллагын цахим шуудан, домэйн нэр олгох үйлчилгээний гэрээ байгуулан, байгууллагын info, админ болон албан хаагчдын @umch.ub.gov.mn хаягийг нээн ашиглуулж, төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл илгээх, солилцохтой харилцааг хувийн мэйл хаяг ашиглалтыг зогсоож, албаны мэйл хаяг ашиглах боломжийг бүрдүүлэв.4. МУ-ын Засгийн газраас Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас буюу Удирдлагын систем gov.mn-д байгууллагын мэдээллийг байршуулах админ эрх авах, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем буюу байгууллагаас ашиглаж буй албаны системийн хяналт, бүртгэлжүүлэлттэй холбоотой системийн админ эрх авах болон НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй Ulaanbaatar.mn , Улаанбаатар мэдээ сайтуудад байгууллагын мэдээ мэдээлэл солилцох, нийтлүүлэх талаар харилцаа, хамтын ажиллагааг ханган ажиллалаа.		
--	--	--	--	---	--	--

11	<p>Арга хэмжээ 3.3 Гадаад хамтын ажиллагаатай холбоотой төлөөллийн хурал, уулзалт, сургалт семинар, айлчлалыг зохион байгуулах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь</p>	0%	60%	<p>"ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН НЭГДСЭН ЦАХИМ СИСТЕМ"-ийн сургалтыг Нийслэлийн Өмчийн харилцааны газраас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран нийслэл дэх төрийн өмчийн 541 хуулийн этгээд, нийслэлийн өмчит 933 хуулийн этгээдэд "Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем"-ийг нэвтрүүлэх, цаашид өмчийн харилцааны бүхий л үйл ажиллагааг цахимаар, ил тод нээлттэй зохион байгуулах зорилгын хүрээнд 2025.10.23-30-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд нийслэлийн 4 байршилд 6 удаагийн зохион байгуулалтаар нийт 4000 гаруй албан хаагчид хамрагдсан.</p> <p>Тус арга хэмжээний Соёлын төв өргөө болон Монголын Хүүхдийн ордон дахь сургалтуудын зохион байгуулалт, нээлтийн үйл ажиллагааны фото болон видео архив, цахим хуудас https://www.umch.ub.gov.mn/a/1078 дээрх мэдээллийг хийн ажиллалаа.</p>	06-12	100%
Зорилго 4. ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАН АЖИЛЛАХ							
12.	<p>Арга хэмжээ 4.1 Байгууллагын дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг тайлагнах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь</p>	0%	80%	<p>2025 оны байдлаар байгууллагын алба, нэгжүүд хоорондын зорилгоо уялдуулан хамтран ажиллах үйл явц, уялдаа холбоог сайжруулж, ажлын үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Дотоод хамтын ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулан ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөнд дараах чиглэлүүдийг тусгасан:</p> <ul style="list-style-type: none"> • Хэлтэс, нэгж хоорондын мэдээлэл солилцооны үр нөлөөг сайжруулах 	06-12	100%

					<ul style="list-style-type: none"> • Дотоод сургалт, туршлага хуваалцах уулзалтууд зохион байгуулах • Багаар ажиллах соёлыг төлөвшүүлэх арга хэмжээнүүд зохион байгуулах • Байгууллагын уур амьсгалыг сайжруулах өдөрлөг зохион байгуулах. Жишээ нь: ууланд алхах, harry hour хийж цайны цагаараа дулаан яриа өрнүүлэх, туршлагатай албан хаагчдаасаа туршлага хуваалцах өдөрлөг зохион байгуулах • Спортоор хичээллэх. Жишээ нь: Байгууллагаараа 1/7 хоног бүүр зааланд тоглох, байгууллага нийтээрээ өглөө болон өдөр 10-15 минут дасгал хөдөлгөөн хийх, дугуй унах, фитнесс иога хийх, марафонд гүйх, нийт албан хаагчид санамсаргүй байдлаар холилдон багт хуваагдаж нөхөрсөг тэмцээн зохиох • Хамтын хэлэлцүүлэг, санал • Ажилтны сэтгэл ханамжийн судалгаа явуулах <p>гэх мэт арга хэмжээнүүдийг тусгаж 2026 оны дотоод хамтын ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулахаар бэлтгэж байна.</p>		
13.	Арга хэмжээ 4.2 Байгууллагын дотоод үйл ажиллагааны зохион байгуулалтыг ханган ажиллах, албан хаагчдыг мэдээ мэдээллээр хангах	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0%	50%	Байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нийт албан хаагчдад цаг тухайд нь танилцуулах, мэдээллээр хангах, санал авах болон үйл ажиллагааны зохион байгуулалтыг ханган ажиллалаа. Үүнд:	06-12	100%

					<ul style="list-style-type: none"> <p>НЗДТГ, МУ-ын Засгийн газар, Монгол Улсын Ёс зүйн хороо, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Статистикийн газар, Улаанбаатар театр ОНӨТҮГ, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ болон Налайх дүүргийн ЗДТГ-аас ирүүлсэн албан тоот бичгүүдийн хүрээнд холбогдох судалгааг авч, албан хаагчдад танилцуулж, идэвхтэй хамруулав. Үүнд: Тэрбум мод үндэсний хөдөлгөөн буюу “Бүх нийтээр мод тарих өдөр”, Олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, “Ногоон санаачилга 2025” туршлага, судалгааны өдөрлөг, Хүн ам, орон сууцны улсын тооллого, “Хүндэлье, Энэрье-2025” ёс зүйн нөлөөллийн аян, Соёл түгээе аян, Авлигын эсрэг нэгдье аян, “Хүүхдийн төлөө-миний сонголт” аян, Угаарын хийн эрсдэлээс сэргийлье аян, Олон улсын дохионы хэлний өдөр, Дэлхийн ёс зүйн өдөр зэрэг арга хэмжээний судалгаа, зохион байгуулалт, албан бичгүүдийн хэрэгжилтийг хангаж, холбогдох мэдээ мэдээлэл, постер, мэндчилгээ, уриалга зэргийг бэлтгэн</p> <p>https://www.umch.ub.gov.mn/ https://www.facebook.com/umch.ub.gov.mn</p> <p>байгууллагын цахим хуудсууд болон нийслэлийн UB.ERP системийн үйл явдал хэсгүүдэд тус тус байршуулан ажиллалаа.</p> 		
--	--	--	--	--	---	--	--

					<ul style="list-style-type: none"> • Мөн НӨХГ-ын албан хаагчид "Say No To Alcohol" уриалгын хүрээнд 1/7 хоног бүр спортоор хичээллэж, цагийг эрүүл, үр бүтээлтэй өнгөрүүлж байгаа бөгөөд заалны цаг авах, зааланд тоглох мэдээллийг хүргэх зэрэг зохион байгуулалтыг ханган ажиллалаа. • "ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН НЭГДСЭН ЦАХИМ СИСТЕМ"-ийн сургалтыг Нийслэлийн Өмчийн харилцааны газраас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран 2025.10.23-30-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд нийт 4000 гаруй албан хаагчид хамрагдсан. Тус арга хэмжээний зохион байгуулалт, нээлтийн үйл ажиллагааны фото болон видео архив, цахим хуудас дээрх https://www.umch.ub.gov.mn/a/1078 мэдээллийг хийн ажиллалаа. 		
14.	Арга хэмжээ 4.3 Байгууллагатай холбоотой зохион байгуулагдаж буй арга хэмжээ, үйл ажиллагааг баримтжуулж, фото архив үүсгэх	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0%	60%	Байгууллагын дотоодод зохион байгуулагдаж буй үйл ажиллагаа, сургалт семинар, спортын үйл ажиллагаа болон албан бичгийн хүрээнд зохион байгуулагдаж буй арга хэмжээ, үйл ажиллагааг баримтжуулж, фото архив үүсгэж байгаа бөгөөд нийслэлийн архивын шалгалтын үеэр 2025 оны 02 сараас 10 дугаар сарын хооронд үүссэн фото архивуудыг мэргэжилтэн М.Энхбаярт хүлээлгэн өгсөн ба түүнээс хойш үүссэн хадгаламжийн нэгжүүдийг жилийн эцэст НӨХГ-ын архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэж байна.	06-12	100%
Зорилго 5. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ							

15.	<p>Арга хэмжээ 5.1 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь</p>	0%	50%	<p>Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-ийн 8.1 дүгээр зүйл, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтын дагуу байгууллагатай холбоо хамаарал бүхий ил тод, нээлттэй байршуулах 41 төрөл, зүйлийн нээлттэй мэдээллийг байгууллагын цахим хуудас https://www.umch.ub.gov.mn/, шилэн данс систем https://shilendans.gov.mn/organization/11573?ry=2025&group=117 ; Шил ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд https://shilen.gov.mn/ -д байршуулж ажиллалаа.</p> <p>Байгууллагын цахим хуудас https://www.umch.ub.gov.mn/ , олон нийтийн сүлжээний фэйсбүүк платформ https://www.facebook.com/umch.ub.gov.mn -д байгууллагын үйл ажиллагааг нийтэд мэдээллэн, мэдээ мэдээллийн баяжилтыг өдөр бүр хийж байна. Түүнчлэн олон нийтийн сүлжээний ютүб https://www.youtube.com/@%D0%9D%D3%A8%D0%A5%D0%93 , инстаграм https://www.instagram.com/umch_ub_official/ хуудсуудын хөтлөлт, ашиглалтыг хийж түүгээр дамжуулан байгууллагын дотоодын болон гадагшаа чиглэсэн үйл ажиллагааны мэдээ мэдээллийг, иргэд олон нийтэд олон сувгаар хүргэх ажлыг хийж гүйцэтгэж байна.</p>	06-12	100%
16.	<p>Дэд арга хэмжээ 5.1.1: Байгууллагын мэдээллийн самбар, үндсэн цахим хаяг, нийгмийн сүлжээний платформ фэйсбүүк пэйж хуудасны хөгжүүлэлтийг хийж, бүрдлийг хангах</p>	<p>Үндсэн арга хамжээний гүйцэтгэлд эзлэх хувь</p>	0%	15%	<p>НӨХГ-ын https://www.umch.ub.gov.mn/ вэб сайтыг хөгжүүлэгч Sodonsolution ХХК-аас зааварчилгаа, зөвлөгөө авч сайтын засвар, хөгжүүлэлт, шаардлагатай байгаа цэс, график, текст, холбоосуудыг оруулж вэб сайт болон фэйсбүүк пэйж хуудасны баяжилт, олон нийтийн сүлжээний ютүб, инстаграм хуудсуудын хөтлөлт,</p>	06-12	100%

					<p>ашиглалтыг хийж нийгмийн сүлжээний платформын бүрдлийг хангаж ажиллалаа.</p> <p>Байгууллагын мэдээллийн самбарын бүрдэл, ашиглалтыг сайжруулж, нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтүүдийг QR код уншуулан байгууллагын цахим хуудасны цэсүүд рүү хялбар нэвтрэх боломжийг бүрдүүлж ажиллалаа.</p>		
17.	<p>Дэд арга хэмжээ 5.1.2: Байгууллагын мэдээллийн самбар, цахим хаягууд болон shilen.gov.mn хуудсуудад байгууллагын танилцуулга, зорилго, зорилтууд, үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, иргэн, ААН-д үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг байршуулах</p>	<p>Үндсэн арга хамжээний гүйцэтгэлд эзлэх хувь</p>	0%	10%	<p>Байгууллагын цахим хаяг https://www.umch.ub.gov.mn/ -д</p> <ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын товч танилцуулга болон газрын дарга, хэлтэс нэгжүүдийн танилцуулга https://www.umch.ub.gov.mn/p/170 , https://www.umch.ub.gov.mn/p/168 , https://www.umch.ub.gov.mn/p/175 , https://www.umch.ub.gov.mn/p/176 , https://www.umch.ub.gov.mn/p/177 , https://www.umch.ub.gov.mn/p/178 ➤ Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги зорилтууд https://www.umch.ub.gov.mn/p/2 ➤ Байгууллагын бүтэц, зохион байгуулалт https://www.umch.ub.gov.mn/p/14 ➤ Байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл https://www.umch.ub.gov.mn/p/173 -ийг холбогдох холбоосоор оруулж бүрдлийг ханган ажиллалаа. ➤ Түүнчлэн фэйсбүүк пэйж хуудас болон мэдээллийн самбар дээр дээрх холбоосууд руу QR код уншуулан хялбар 	06-12	100%

					<p><i>нэвтрэх боломжийг бүрдүүлж ажиллалаа.</i></p> <p>Shilen.gov.mn-д холбогдох мэдээлэл байршсан байгууллагын цахим хаяг, шилэн данс системийн холбоосууд, холбогдох бичгийн pdf файл болон сайт, пэйж, мэдээллийн самбар дээр хэрхэн байршсан талаарх зураг, мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эрх бүхий албан хаагчийн мэдээллийг тус бүрд хавсарган байршуулав.</p>		
18.	<p>Дэд арга хэмжээ 5.1.3: Байгууллагын мэдээллийн самбар, цахим хаягууд болон shilen.gov.mn хуудсуудад байгууллагаас болон Нийслэлээс зохион байгуулсан ажлын талаарх мэдээний эх бэлтгэж олон нийтэд үнэн бодит, тэнцвэртэй мэдээллийг түгээх</p>	<p>Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь</p>	0%	150	<p>НӨХГ сайт, фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан байгууллагын дотоодын болон гадагшаа чиглэсэн мэдээ мэдээллийн эх бэлтгэж нийтлэх, түүнчлэн НЗДТГ-ын Улаанбаатар мэдээ https://www.facebook.com/UlaanbaatarMedeeMN болон https://www.ulaanbaatar.mn/ сайтын мэдээ мэдээлэл, бусад нийслэлийн харьяа агентлаг, ННЗБ-уудын онцлох мэдээ мэдээллийг өдөр бүр нийтэлж, олон нийтийг нийслэлд болж буй үйл ажиллагаа, арга хэмжээ, бүтээн байгуулалттай холбоотой мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>2025 оны байдлаар сайтад байгууллагын мэдээ мэдээлэл-80 , түрээслэгч сонгон шалгаруулах зар-114, өмчийн дуудлага худалдааны зар-13, фото мэдээ-62, Нийслэл, ННЗБ-уудын онцлох мэдээ мэдээлэл буюу цаг үеийн мэдээ мэдээлэл- 590 гаруй нийтлэгдлээ. Доорх холбоосоор мэдээллүүдийг байршууллаа.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Цаг үеийн мэдээ, мэдээлэл https://www.umch.ub.gov.mn/as/news/1 ➤ Байгууллагын мэдээ, мэдээлэл https://www.umch.ub.gov.mn/as/news/3 	06-12	100%

					<ul style="list-style-type: none"> ➤ Фото мэдээ https://www.umch.ub.gov.mn/as/news/2 ➤ Сонгон шалгаруулах зар https://www.umch.ub.gov.mn/as/selection ➤ Дуудлага худалдааны зар https://www.umch.ub.gov.mn/as/auction ➤ Фэйсбүүк пэйж https://www.facebook.com/umch.ub.gov.mn 		
19.	<p>Дэд арга хэмжээ 5.1.4: Байгууллагын мэдээллийн самбар, цахим хаягууд болон shilen.gov.mn хуудсуудад НЗД-ын захирамж, НИТХ-ын тогтоол, Газрын даргын тушаал болон газрын дүрэм, журам зэрэг захирамжлахын баримтуудын баяжилтыг хийх</p>	<p>Үндсэн арга хамжээний гүйцэтгэлд эзлэх хувь</p>	0%	15%	<p>Байгууллагын цахим хаяг https://www.umch.ub.gov.mn/ -д</p> <ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын мөрдөж буй хууль, эрх зүйн актууд https://www.umch.ub.gov.mn/p/61 , ➤ Үйл ажиллагаандаа мөрдөж буй дүрэм, журам https://www.umch.ub.gov.mn/p/185 ➤ 2024, 2025 оны Нийслэлийн Засаг даргын захирамж https://www.umch.ub.gov.mn/p/189 , https://www.umch.ub.gov.mn/p/171 ➤ 2024, 2025 оны НИТХ тогтоол https://www.umch.ub.gov.mn/p/188 , https://www.umch.ub.gov.mn/p/179 ➤ 2024, 2025 оны Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын тушаал https://www.umch.ub.gov.mn/p/187 , https://www.umch.ub.gov.mn/p/183 -ыг тус тус холбогдох холбоосоор байршуулж, бүрдлийг ханган ажиллалаа. Түүнчлэн фэйсбүүк пэйж хуудас, мэдээллийн самбар дээр эдгээр холбоос руу нэвтрэх боломжтой QR кодыг байршууллаа. <p>Shilen.gov.mn-д холбогдох мэдээлэл байршсан байгууллагын цахим хаяг, шилэн данс системийн холбоосууд, холбогдох бичгийн pdf файл болон сайт, пэйж, мэдээллийн самбар дээр</p>	06-12	100%

					хэрхэн байршсан талаарх зураг, мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эрх бүхий албан хаагчийн мэдээллийг тус бүрд хавсарган байршуулав.		
20.	<p>Дэд арга хэмжээ 5.1.5: Байгууллагын мэдээллийн самбар цахим хаяг болон shilen.gov.mn хуудсуудад байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөцийн ил тод байдалд холбогдох мэдээллүүдийг бүрэн байршуулах, байнгын шинэчлэх</p>	Үндсэн арга хамжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	15%	<p>Байгууллагын цахим хаяг https://www.umch.ub.gov.mn/ -д</p> <ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын албан хаагчдын мэдээлэл, өрөөний дугаар, холбоо барих утас болон цахим шуудангийн хаяг https://www.umch.ub.gov.mn/p/c/26 ➤ Төсөв санхүүгийн ил тод байдлын хүрээнд байгууллагын шилэн дансанд “Төсөв, гүйцэтгэл”, “хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт”, “бусад” зэрэг нийт 42 мэдээллийг байршуулсан. Мөн байгууллагын цахим хуудаст батлагдсан төсвийн талаарх мэдээлэл, 2024 оны санхүүгийн тайлан, тайланд хийсэн аудитын хяналт шалгалтын тайлан, дүгнэлт, нэмэлт санхүүжилтийн талаарх мэдээлэл, төсвийн хэмнэлт, хэтрэлтийн талаарх мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө https://shilendans.gov.mn/organization/11573?ry=2025&group=117, https://www.umch.ub.gov.mn/p/c/31, https://www.umch.ub.gov.mn/p/c/34, https://www.umch.ub.gov.mn/p/c/35, https://www.umch.ub.gov.mn/p/c/36, https://www.umch.ub.gov.mn/p/c/37, https://www.umch.ub.gov.mn/p/c/40, https://www.umch.ub.gov.mn/p/c/33 ➤ Үйл ажиллагааны ил тод байдал буюу үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, үйл ажиллагааны статистик 	06-12	100%

